



**НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 09 сарын 10 өдөр

Дугаар 8/30

Улаанбаатар хот

┌ “Автомашингүй өдөр” арга хэмжээний
хүрээнд спортын уралдаан тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1256 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Автомашингүй өдөр” арга хэмжээний хүрээнд спортын уралдаан тэмцээнийг 2025 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2. “Автомашингүй өдөр” арга хэмжээний хүрээнд спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. “Автомашингүй өдөр” арга хэмжээний хүрээнд спортын уралдаан тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 15,140,000 (арван таван сая нэг зуун дөчин мянга) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын нэмэлт дансны холбогдох зардлаас гаргахыг Нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

4. Тэмцээний урьдчилсан бэлтгэл ажлыг сайтар хангаж, спортын холбоодтой хамтран ажиллаж, иргэдийг өргөнөөр хамруулан зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн Төрийн болон аж ахуйн нэгж байгууллага дахь биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн Ө.Мягмаржавд даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Цогзолмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны
өдрийн 1/30 дугаар тушаалын хавсралт

**“АВТОМАШИНГҮЙ ӨДӨР” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ СПОРТЫН УРАЛДААН ТЭМЦЭЭН**

№	Зардлын нэр		Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төгрөг/
1.3х3 сагсан бөмбөгийн тэмцээн					
1	Багийн шагнал (өсвөр, залуучууд, эрэгтэй, эмэгтэй)	1-р байр	4 баг	200,000	800,000
2		2-р байр	4 баг	150,000	600,000
3		3-р байр	4 баг	100,000	400,000
4	Шүүгчдийн зардал		1 өдөр х 5 хүн	150,000	750,000
5	Зөөврийн шийдийн түрээс		1	1,000,000	1,000,000
6	Тээврийн зардал		1 өдөр х 2 удаа	300,000	600,000
7	Хөгжим, үзель		1 өдөр	1,000,000	1,000,000
Дүн					5,150,000
2.Спорт бүжгийн тэмцээн					
1	Багийн шагнал (өсвөр, залуучууд, 2 төрлөөр)	1-р байр	4 баг	200,000	800,000
2		2-р байр	4 баг	150,000	600,000
3		3-р байр	4 баг	100,000	400,000
4	Шүүгчдийн зардал		1 өдөр х 4 хүн	150,000	600,000
5	Багийн өргөмжлөл		12 ш	5000	60,000
Дүн					2,460,000
3.Дугуйн тэмцээн					
1	Бага, өсвөр нас нийт 6 насны ангиллаар	1-р байр	6 хүн	100,000	600,000
2		2-р байр	6 хүн	80,000	480,000
3		3-р байр	6 хүн	60,000	360,000
4	Шүүгчдийн зардал		1 өдөр х 4 хүн	150,000	600,000
5	Тээврийн зардал		1 удаа	540,000	540,000
Дүн					2,580,000
4.Кроссфитын тэмцээн					
1	Өсвөр, залуучууд 4 насны ангиллаар эрэгтэй эмэгтэй	1-р байр	8 хүн	200,000	1,600,000
2		2-р байр	8 хүн	150,000	1,200,000
3		3-р байр	8 хүн	100,000	800,000
4	Шүүгчдийн зардал		1 өдөр х 5 хүн	150,000	750,000
5	Тээврийн зардал		4 удаа	300,000	600,000
Дүн					4,950,000
Нийт					15,140,000

تاریخ: ۱۳۹۴/۰۵/۰۵
 شماره: ۵۵

قفسه: ۵۵
 شماره: ۵۵

بخش: ۵۵
 شماره: ۵۵

«...»
 ...

...
 ...

...

...

...

...

...

...